



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/12

Нарийнтээл сум

Албан тушаалын тодорхойлолт батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай" 03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 5.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Насан туршийн суралцахуйн нэгжийн багшийн албан тушаалын тодорхойлолтыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан албан тушаалын тодорхойлолтыг 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Насан туршийн суралцахуйн нэгжийн багшид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/13

Нарийнтээл сум

Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Монгол Улсын иргэнд Газар өмчлүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйл, 7 дугаар зүйлийн 7.1 дэх, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.3 дахь заалт, 21 дүгээр зүйл, Монгол Улсын иргэнд "Газар өмчлөх тухай хууль"-ийн дагаж мөрдөх журмын 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын "Газар өмчлүүлэх тухай" 2008 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 39 тоот Захирамжийн 26-т байгаа 1 өрхийн 2 иргэний хүсэлтийн дагуу газар өмчлөх эрхийг 1 дүгээр хавсралтаар хүчингүй болгож, иргэн Э.Банзрагчид 2 дугаар хавсралтаар газар өмчлөх эрхийг шилжүүлсүгэй.

2.Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар хашааны газар өмчлөн авч буй нэр бүхий иргэнд өмчилж авсан газраа үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэн, баталгаажуулж, Монгол Улсын иргэнд Газар өмчлүүлэх хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай

3.Газар өмчлөх эрхийг хүчингүй болгосон газарт хэмжилт хийж, нэр бүхий иргэн дээр баталгаажуулан, газар өмчлөгчид хүлээлгэн өгөхийг газрын даамал (Н.Мягмаржав)-д хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



Нарийнтээл сумын Засаг даргын 2025 оны 09 сарын 14-ны өдрийн 113 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХИЙГ ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ

Эзэмшигчийн			Хамтран өмчлөгчид				Газрын			
Овог	Эцэг/эх/-ийн нэр	Нэр	Регистр	Эцэг/эх/-ийн нэр	Нэр	Өмчлөгийн хэн болох	Регистр	Байршил	Хэмжээ	Газрын үнэ /мян,тө/
Өшгөг	Эрдэнэочир	Банзрагч	ЙТ81020915					Баянтээг 2-р баг Тээг -3- 22 тоот	1052	1472800



Нарийнтээл сумын Засаг даргын 2025 оны ...
сарын ... -ны өдрийн ... дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ

Д/д	Эзэмшигчийн				Регистр	Урьд нь газар өмчлүүлсэн захирамжийн дугаар, огноо	Газрын		
	Овог	Эцэг/эх/- ийн нэр	Өөрийн нэр	Оршин суугаа хаяг			Байршил	Хэмж ээ	Газрын үнэ /мян,тө/
1	Лхагважав	Сэргэлэн	Балжмаа	Баянтээг 2-р баг Тээг 4-4 ТООТ	ВЭ84020201	2008/39	Баянтээг 2-р баг Тээг 3-22 ТООТ	1052	1472800
2	Өшгөг	Банзрагч	Амардулам	Баянтээг 2-р баг Тээг 4-4 ТООТ	ВЮ06320821		Баянтээг 2-р баг Тээг 3-22 ТООТ	1052	1472800

_____ооо_____



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/14

Нарийнтээл сум

2024 оны сумын тэргүүнүүд шалгаруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар 25-ны өдрийн "Сумын 2025 оны төсөв батлах тухай" 03/05 дугаар хуралдааны тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны сумын Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилтуудыг ханган биелүүлж тухайн салбарт эрхэлсэн ажилдаа хөдөлмөрийн амжилт гаргасан 1 дүгээр багийн малчин А.Батбаяр, эхнэр Д.Амаржаргал, 2 дугаар багийн малчин Н.Охиноо, эхнэр Д.Энхбаяр, Ц.Машбат, эхнэр П.Гэрэлмаа, 3 дугаар багийн малчин Л.Баттөмөр, эхнэр Ю.Баатарбаяр, Г.Чимэдцэрэн, эхнэр Ж.Загарзүсэм, 4 дүгээр багийн малчин Б.Батмөнх, эхнэр Х.Амгалан, Г.Батпүрэв, эхнэр Н.Энхцэцэг, Б.Сугарсанчир, эхнэр А.Гэрэлцэцэг, Д.Баттогоо, эхнэр Д.Булганзаяа нарыг "Сумын аварга малчин"-аар,

1 дүгээр багийн малчин А.Батсүрэн, эхнэр О.Насандулам, 1 дүгээр багийн малчин Д.Баярмагнай, эхнэр Г.Сэрчинням, 3 дугаар багийн малчин Б.Пүрэв, эхнэр Б.Чулуунхорол, 4 дүгээр багийн малчин Д.Амартүвшин, эхнэр Б.Долгорсүрэн, А.Найдан, эхнэр Долгордулам, Д.Батболд, эхнэр Д.Идэрнасан нарыг "Сумын Мянгат малчин"-аар

3 дугаар багийн малчин Г.Дорждэрэм, 3 дугаар багийн малчин Ч.Батжаргал, эхнэр Д.Гануяа нарыг "Сумын аварга үхэрчин"-ээр

1 дүгээр багийн малчин С.Нямдаш, эхнэр З.Дэмбэрэлдулам, 2 дугаар багийн малчин Д.Баттөр, эхнэр О.Долгорсүрэн, 4 дүгээр багийн малчин Б.Батням, эхнэр Г.Оюунжаргал нарыг сумын "Шилдэг залуу малчин"-аар,

1 дүгээр багийн уяач Ж.Баасандорж, 2 дугаар багийн уяач Ц.Хасбаатар нарыг "Сумын алдарт уяач"-аар

Боловсролын Их Сургуулийн оюутан Ц.Солонго, хувиараа хөдөлмөр эрхлэгч Ц.Анхбаатар нарыг "Сумын мэргэн цол"-оор

Сумын Засаг даргын Тамгын газрын газрын даамал Н.Мягмаржавыг "Сумын Төрийн захиргааны Тэргүүний ажилтан"-аар,

Баянтээг Хүн эмнэлгийн сувилагч М.Батцэцэгийг "Эрүүл мэндийн тэргүүний ажилтан"-аар,

СӨББ-ын багш Г.Ганцэцэгийг "Сумын Боловсролын тэргүүний ажилтан"-аар,

Баянтээг ХК-ны краны операторчин Ш.Лхавгадоржийг "Сумын эрчим хүч, уул уурхайн тэргүүний ажилтан"-аар

ЕБСургуулийн дотуур байрны тогооч Д.Оюунбатыг "Сумын төрийн үйлчилгээний тэргүүний ажилтан"-аар

2 дугаар багийн хувиараа хөдөлмөр эрхлэгч Н.Нямхүүг "Сумын үйлдвэр, үйлчилгээний тэргүүний ажилтан"-аар

"Аварга" дээд сургуулийн оюутан С.Өлзийбатыг "Сумын тэргүүний оюутан"-аар

Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагч Г.Шинэжилийг "Сумын Тэргүүний сурагч"-аар тус тус шалгаруулсугай.

2.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтуудыг ханган биелүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж, өөрийн салбартаа хамт олноо манлайлан ажилласан А.Баттогтох, Т.Гантөмөр, Ж.Цэрэннадмид, Б.Ганцэцэг, Н.Даваасамба, Ж.Мягмардорж нарыг "Сумын Засаг даргын баярын бичиг"-ээр тус тус шагнасугай.

3.2024 оны Сумын тэргүүнүүдийг шагнаж урамшуулах зардлыг хавсралтаар баталсугай.

4.2024 оны сумын тэргүүнүүдийг шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Ичинноров)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



СОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/15

Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5, 2.1.6, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар 25-ны өдрийн "Сумын 2025 оны төсөв батлах тухай" 03/05 дугаар хуралдааны тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны сумын тэргүүнүүдийг шалгаруулах арга хэмжээний зардалд 5,051,000 (таван сая тавин нэгэн мянган) төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар баталсугай.


2.Дээрх зардлыг Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР

Нарийнтээл сумын Засаг даргын 2025
оны 09 дугаар сарын 12 ны өдрийн А/5
дүгээр захирамжийн хавсралт



СУМЫН АВАРГУУДЫН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/
1	Мөнгөн шагнал	ш	14	30,000	420,000
2	Хувин	ш	11	210,000	2,310,000
3	Өргөмжлөл	ш	26	20,000	520,000
4	Тэмдэг	ш	39	10,000	390,000
5	Тууз	ш	28	15,000	420,000
6	Үнэмлэх	ш	4	4250	17,000
7	Боорцог	ш	9	6000	54,000
8	Батламж	ш	6	15,000	90,000
9	Баярын бичиг	ш	6	15,000	90,000
10	Өргөмжлөл	ш	5	50,000	250,000
11	Батламж	ш	7	70,000	490,000
Дүн					5,051,000

_____ооо_____



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/16

Нарийнтээл сум

Ажил хүлээлцэх, хяналт тавих
ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4, 48.2.7, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэж байгаа "Мал эмнэлгийн машины засвар"-ын ажилд хяналт тавьж, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Шинэбаатар (Мал аж ахуй асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Д.Бямбадолгор (Мал эмнэлгийн тасгийн дарга)
Э.Мөнхбат (Засаг даргын Тамгын газрын нярав)
А.Батмөнх (Засаг даргын Тамгын газрын жолооч)
Н.Гантулга (Иргэний төлөөлөл)

2.Мал эмнэлгийн машины засварын ажилд хяналт тавьж, хүлээн авч, орон нутгийн өмчид бүртгэн, архивын нэгж бүрдүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Шинэбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/17

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Улиастайн аманд худаг гаргах" ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Наранбаатар (Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: С.Амаржаргал (Жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

О.Цэрэннадмид (1 дүгээр багийн Засаг дарга)

А.Батмөнх (Засаг даргын Тамгын газрын жолооч)

Нарийн бичгийн дарга: Т.Батдулам (Насан туршийн суралцахуйн нэгжийн багш)

2.Бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа худалдан авах ажиллагааны журмыг мөрдөн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Наранбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/22

Нарийнтээл сум

Тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын иргэн Балжиннямын Баатарын эмчилгээний зардалд зориулан 1,300,000 (нэг сая гурван зуун) мянган төгрөгийн тусламж үзүүлсүгэй.

2.Дээрх зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/23

Нарийнтээл сум

Тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын иргэн Найдангомбын Мягмаржавын эмчилгээний зардалд зориулан 1,000,000 (нэг сая) төгрөгийн тусламж үзүүлсүгэй.

2.Дээрх зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/24

Нарийнтээл сум

Тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, 2.1.5, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянтээг 2 дугаар багийн иргэн өндөр настан Д.Долгор нь өвчний улмаас нас барсан тул ар гэрт нь 133,000 (нэг зуун гучин гурван мянган) төгрөг, 2025 оны аймгийн аварга шалгаруулах "Гар барилдаа"-ны зардалд 66,500 (жаран зургаан мянга таван зуун) төгрөгийн тусламж үзүүлсүгэй.

2.Дээрх 199,500 төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/25

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 257 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Угийн бичиг хөтлөх журам"-ын 1.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн "Угийн бичгийн хөтлөлтийг эрчимжүүлэх тухай" 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд өрх бүрийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2.Угийн бичиг хөтлөх ажилд төрийн албан хаагчдыг манлайлан оролцуулж, тэдэнд дэмжлэг, урамшуулал үзүүлэн ажиллахыг байгууллагын дарга эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Угийн бичиг хөтлөх ажилд төрийн албан хаагчдаа хамруулж, нийт иргэдэд угийн бичиг хөтлөлтийн ач тусын талаар сурталчлан таниулж, уриалж ажиллахыг төсөвт байгууллагын дарга эрхлэгч нар даалгасугай.

4.Угийн бичиг хөтлүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (М.Ганжаргал)-д даалгасугай.

5.Энэ захирамж гарсантай холбогдуулан 2024 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн а/19 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР

Р 0225112-0

Сумын Засаг даргын 2025 оны 09 дугаар
сарын 11-ны өдрийн 125 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



УГИЙН БИЧИГ ХӨТЛҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга: Соёлын төвийн эрхлэгч

Гишүүд: Сургуулийн номын санч

Эрүүл мэндийн эх баригч эмч

Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Насан туршийн суралцахуйн нэгжийн багш

СӨББ-ын арга зүйч

Сургуулийн нийгмийн ажилтан

Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан

Багийн Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: Соёлын төвийн номын санч

— оОо —



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/26

Нарийнтээл сум

Ажил хүлээлцэх ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4, 45.5 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Баянтээг багийн СӨББ-ын барилгыг засварлах, өргөтгөх ажил”-ыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Мягмаржав (Газрын даамал)

Гишүүд: Д.Чимэгмаа (Баянтээг багийн СӨББ-ын эрхлэгч)

Б.Базарсад (Баянтээг 2 дугаар багийн Засаг дарга)

Э.Мөнхбат (Засаг даргын Тамгын газрын нярав)

Б.Дуламжаргал (Баянтээг багийн СӨББ-ын багш)

С.Даваадулам (Баянтээг багийн СӨББ-ын тогооч)

Нарийн бичгийн дарга: Б.Лхамсүрэн (Төсөв төрийн сангийн мэргэжилтэн)

2.Дээрх ажлыг холбогдох хууль, журмын дагуу хүлээн авч Засаг даргын зөвлөлд тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Мягмаржав)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/27

Нарийнтээл сум

Тамхины зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Зөвшөөрлийг тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 5.3.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.9 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тамхи худалдаалах, түүгээр үйлчлэх аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тавигдах шаардлагыг хангасан "Таац-2" хүнсний дэлгүүрт 2 жилийн хугацаатай тамхины зөвшөөрөл олгосугай.

2.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий худалдааны газруудад хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (С.Баасандулам), Хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч (У.Мягмарнасан) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 27 өдөр

Дугаар A/28

Нарийнтээл сум

Эргүүл жижүүр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн "Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай" 109 дүгээр тогтоол, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Элдэв эрдэнэт" модон могой хэмээх жилийн билгийн тооллын хаврын тэргүүн сарын баярын үеэр гэмт хэрэг, хэв журмын зөрчил гарахаас урьдчилан сэргийлж, ард иргэдийн амгалан тайван байдлыг сахин хамгаалж, байгууллагуудын дулаан халаалтын хэвийн ажиллагааг хангах зорилгоор хариуцлагатай эргүүл жижүүрийг 2025 оны 02 дугаар сарын 28 -ны өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийг хүртэлх хугацаагаар ажиллуулсугай.

2.Цагаан сарын үеэр ажиллах хариуцлагатай эргүүл жижүүрийн нэрс, хуваарийг хавсралтаар баталсугай.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч (У.Мягмарнасан), Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн (С.Баасандулам), Баянтээг 2 дугаар багийн Засаг дарга (Б.Базарсад) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 27 өдөр

Дугаар A/29

Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын төвийн бүх нийтийн хог цэвэрлэгээний зардалд 133,000 (нэг зуун гучин гурван мянган) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх 133,000 төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР